



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр, Даваа гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 - 6

- 1. Түр хорооны тогтоолын төсөл /Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий “Хянан шалгах түр хорооны даргыг сонгох тухай”/ 4 - 6*
-

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Хянан шалгах түр хороо /Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний
хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл
ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий/-ны
04 дүгээр сарын 15-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 5 гишүүнээс 3 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 44 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адьяаа;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Энх-Амгалан.

Нэг.Түр хорооны тогтоолын төсөл /Хянан шалгах түр хорооны даргыг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Болорсүх, мөн хэлтсийн зөвлөх Ж.Монголжингоо, референт Р.Дүүрэнбаяр, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4-т Улсын Их Хурлын гишүүний өмнөх, эсхүл одоогийн үйл ажиллагаа нь тусгай шалгах тухайн асуудалтай холбоотой бол уг гишүүнийг түр хорооны гишүүнд оруулахыг хориглоно гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Ц.Сандаг-Очир, Ц.Цэрэнпунцаг нар ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ мэдэгдэв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийг Хянан шалгах түр хорооны даргад нэр дэвшүүлэх саналыг гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийг сонгох нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 0

Бүгд: 3

100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг “Хянан шалгах түр хорооны даргыг сонгох тухай” түр хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: “Хянан шалгах түр хорооны даргыг сонгох тухай” түр хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 0
Бүгд: 3
100 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Түр хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 8 минут үргэлжилж, 5 гишүүнээс 3 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 52 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим
16 цаг 44 минут

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Цэрэнпунцаг: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 25 дугаар тогтоолоор байгуулагдсан “Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий” Хянан шалгах түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул түр хорооны 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Гишүүдийн ирцийг танилцуулъя. Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн байна, Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн ирсэн байна, Бямбасүрэнгийн Энх-Амгалан одоогоор эмнэлэгт үзүүлж явна гэсэн. Өнөөдрийн хуралд ирж амжаагүй байна. Ширнэнбаньдийн Адьшаа гишүүн Завхан аймагт томилоттой ажиллаж байна. Тогмидын Доржханд гишүүн ирсэн байна.

Ингээд гишүүдийн ирц 60.0 хувьтай бүрдэж, өнөөдрийн хуралдааныг нээе.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя.

Хэлэлцэх асуудал нэг. Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий “Хянан шалгах түр хорооны даргыг сонгох тухай” тогтоолын төсөл.

Энэ дээр асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4-т Улсын Их Хурлын гишүүний өмнөх, эсхүл одоогийн үйл ажиллагаа нь тусгай шалгах тухайн асуудалтай холбоотой бол уг гишүүнийг түр хорооны гишүүнд оруулахыг хориглоно гэж заажээ.

Тиймээс гишүүд энэ талаар саналтай бол одоо мэдэгдэнэ үү? Ашиг сонирхлын зөрчилтэй байна уу, үгүй юу гэсэн асуулт байна.

Тийм учраас 2 гишүүнээсээ ашиг сонирхлын зөрчил байна уу, үгүй юу? Т.Доржханд гишүүн Та хариулах уу? Микрофонд хариулаад явчихъя. Тэгэх үү.

Т.Доржханд: Ашиг сонирхлын зөрчил байхгүй. Ямар нэгэн лиценз, уул уурхайн зориулалттай лиценз болон энэ чиглэлээр ажилладаг ямар нэгэн холбоо хамаарал байхгүй.

Ц.Цэрэнпунцаг: Ц.Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Надад ямар нэгэн ашиг сонирхол, ашигт малтмал

хайх, ашиглах зориулалтаар газар, түүнтэй холбоотой лиценз юм байхгүй.

Ц.Цэрэнпунцаг: 2 гишүүндээ баярлалаа.

Миний хувьд ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй лиценз шууд эзэмшдэггүй.

Олон улсын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа чөлөөтэй арилжаалдаг компанийн хувьд 2017 оноос эхний хувьцааг авч эхлээд энэ компанийн олонх хувьцаа эзэмшиж байгаа.

Уг компани нь Хөвсгөл аймагт ашигт малтмал ашиглах лицензтэй компани.

Энэ 2010 онд “хайгуулын лиценз” аваад, хөрөнгө оруулалтаа хийгээд, тэгээд “ашиглалтын лиценз” болгосон ийм компани байгаа.

Би бол энэ компанийн хувьцааг эзэмшдэг. Хувьцаа эзэмшигчийн хувиар оролцдог. Компанийн үйл ажиллагаанд оролцдоггүй. Хувьцаат компанийн хуулийн дагуу хөрөнгө оруулагч гэсэн нэр томъёотой явдаг.

Ингээд гишүүддээ баярлалаа.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5-д түр хорооны даргыг түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно гэж заасан.

Ингээд түр хорооны даргад нэр дэвшүүлэх саналтай гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг нээе.

Ц.Сандаг-Очир: Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүнийг сонгох саналтай байна.

Ц.Цэрэнпунцаг: Өөр нэр дэвшигч, өөр санал байхгүй бол санал хураалт явуулъя.

Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны даргад нэр дэвшигч Ц.Цэрэнпунцагийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүд 100 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тогтоол.

2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр.

Түр хорооны даргыг сонгох тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх

хэсэг, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 34.4 дэх хэсэг, 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 25 дугаар тогтоолоор байгуулагдсан Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос ТОГТООХ нь:

1. “Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хянан шалгалт хийх” үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцагийг сонгосугай.

2. Энэ тогтоолыг 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Ингээд саяын миний уншсан тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 100 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Ингээд Түр хорооны даргаар итгэл хүлээлгэж сонгосон эрхэм гишүүд Та бүхэндээ баярлалаа.

Ингээд өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж байна. Идэвхтэй оролцсон 2 гишүүндээ.

Хуралдаан 8 минут үргэлжилж, 16 цаг 52 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД